

Маягт СЗХ04008

Даатгалын бүтээгдэхүүний мэдэгдлийн маягт

1	Мэдэгдэл огноо	Он	2021	Сар	03	Өдөр	31
2	Мэдэгдэл гаргагчийн оноосон нэр	БОДЬ ДААТГАЛ ХК					
3	Даатгалын бүтээгдэхүүний нэр	ОПЕРАТОРЫН ХАРИУЦЛАГЫН ДААТГАЛ					
4	Даатгалын бүтээгдэхүүний холбогдох даатгалын хэлбэр	Хариуцлагын даатгал					
5	Даатгалын бүтээгдэхүүнийг борлуулах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр	Шийдвэрийн нэр		Огноо		Дугаар	
		Даатгалын бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулах тухай		2021.03.31		ТУЗ/2107	
6	Цахимаар борлуулах эсэх	<input type="checkbox"/> Тийм <input checked="" type="checkbox"/> Үгүй					
7	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Овог		Нэр			
		Балсан		Баярмагнай			
Мэдээллийн төрлийг сонгоно уу.							
8	Даатгалын бүтээгдэхүүнийг шинээр борлуулах <input checked="" type="checkbox"/> Даатгалын бүтээгдэхүүнийг шинэчлэх						
Даатгалын бүтээгдэхүүний ерөнхий мэдээлэл							
9	Даатгалын зүйл	Даатгуулагч тээврийн хэрэгслийг жолоодох, ажил үйлчилгээ үзүүлж байх үедээ санамсар болгоомжгүй, ур чадвар дутагдсаны улмаас гуравдагч этгээдэд болон операторын өөрийн ашиглаж байгаа тоног төхөөрөмж, машин механизмын өмнө хүлээх хуулийн хариуцлага					
	Даатгалын үндсэн эрсдэл	Даатгуулагч тээврийн хэрэгслээр зам тээврийн хөдөлгөөнд оролцох, үйлчилгээ үзүүлж байх үедээ гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд учруулсан хохирол					
	Даатгалын нэмэлт эрсдэл	- Эмчилгээний зардал /Ослын улмаас жолооч болон зорчигчийн эрүүл мэндэд учирсан бэртэл гэмтлийн үед эмнэлэг эмчилгээний зардал хариуцна/ - Ажил мэргэжлийн алдаа /Тухайн ажилтны ажилдаа гаргасан мэргэжлийн алдаатай үйлдэл, санамсар болгоомжгүй үйлдлийн улмаас ажил олгогчоос хариуцуулсан эд хөрөнгөд, бусдад учруулах хохирол/					
	Даатгалын хураамжийн хувь, хэмжээ	0,6%-3.0%					

ДААТГАЛД ХАМРАГДАХГҮЙ НӨХЦӨЛ

1. Даатгалын зүйл, даатгалын тохиолдлын талаар даатгагчид худал мэдээлсэн, хуурамч бичиг баримт бүрдүүлсэн;
2. Даатгуулагч болон түүний гэр бүлийн гишүүд, түүний эрх ашгийг хамгаалагч гуравдагч этгээдийн санаатай үйлдлээс учирсан хохирол;
3. Машин механизм, Техник тоног төхөөрөмжийг жолоодох эрхгүй этгээд эсвэл жолоодох эрхээ хуульд зааснаар хасуулсан этгээд жолоо барьж явсан тохиолдол;
4. Операторчийн гэрээний хавсралтад заасан машин механизмыг жолоодохоос бусад ажил үйлчилгээ, аливаа үйлдлийн улмаас учруулсан хохирол, гэм хор; мөн Өмчлөгч /ажил олгогчтой/ хөдөлмөрийн гэрээ, ажил гүйцэтгэх гэрээ байгуулахаас өмнө буюу цуцлагдсаны дараа үүссэн хохирол;
5. Машин механизм, Техник тоног төхөөрөмжийн ердийн эвдрэл, элэгдэл хорогдол, үйлдвэрийн гологдол гэмтлийн үр дагавраас болж үүссэн хохирол;
6. Машин механизм, Техник тоног төхөөрөмжийн ашиглалтын горим, зааврыг зөрчсөн, шалган турших зорилгоор, даац, ачаалал хэтрүүлснээс үүссэн хохирол;
7. Даатгалын гэрээнд заагдаагүй эрсдэл, даатгагдаагүй үйл ажиллагааны улмаас учирсан хохирол;
8. Хохирол учирсан нь даатгалын тохиолдлын шинжийг хангаагүй;
9. Хохирол учирсан талаар эрх бүхий байгууллага, даатгагчид нэн дариу мэдэгдэн шалгуулаагүй болон бусад шалтгаанаар даатгалын зүйлд хохирол учирсан шалтгаан тогтоогдоогүй, тодорхой бус байх;
10. Нөхөн төлбөрийн баримтуудыг хүлээлгэж өгөх, нөхөн төлбөрийн нэхэмжлэлийн хүлээлгийн хугацаа дуусгавар болсоноос хойш нөхөн төлбөрийн нэхэмжлэл хүргүүлсэн;
11. Сайн дураар төлсөн болон хүлээн зөвшөөрсөн төлбөр, хохирол;
12. Даатгуулагчийн ажилтан согтууруулах, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэсэн үед учирсан хохирол;
13. Үйлчлүүлэгчийн гаргасан нэхэмжлэлийг шийдвэрлэх шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд даатгагчид оролцох боломжоор хангаагүй;
14. Шалган турших, судалгаа, шинжилгээний ажлын явцад учирсан хохирол;
15. Даатгуулагч нь эрх бүхий байгууллага болон даатгагчийн шаардлага, сануулгыг биелүүлээгүйгээс учирсан хохирол;
16. Гуравдагч этгээдийн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, сэтгэл санаанд учирсан хохирол;
17. Аливаа гэрээний хариуцлага /Даатгуулагчийн үйл ажиллагаатай холбоотой аливаа гэрээний үүрэг биелүүлэхтэй холбоотой хариуцлага, түүнээс үүдэн гарсан хохирол;
18. Хөрөнгийн хохирол /Даатгуулагчийн эзэмшил, түрээс, зээл, хараа хяналтанд байгаа хөрөнгөд учирсан хохирол;
19. Ажил олгогчийн хариуцлага /Монгол улсын хөдөлмөрийн хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, удирдамжаар Даатгуулагч нь ажилтныхаа өмнө хүлээсэн үйлдвэрийн осол түүнтэй холбоотой үүсэх ажил олгогчийн хариуцлага болон тэтгэмж, халамжийн хариуцлага;
20. Байгаль орчинд учирсан хохирол / Гэрээнд өөрөөр заагаагүй бол даатгуулагчийн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд учирсан аливаа хохирол, бохирдол;
21. Гэмт хэргийн шинж чанартай аливаа хохирол;
22. Торгууль, шийтгэвэр, анз, төрийн байгууллагаас ногдуулсан шийтгэвэр, торгууль;
23. Даатгуулагчийн эрхэлж буй үйл ажиллагаа нь зохих лиценз, тусгай зөвшөөрөлгүй тохиолдолд гарсан аливаа хохирол;
24. Даатгуулагчийн ажилчдын нийгэм спортын арга хэмжээнд болон хоол унданд зориулан зарцуулсан бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээнээс үүдсэн хохирол;
25. Тээврийн хэрэгслийн ашиглалттай холбогдон гарах хохирол;
26. Асбестос, бүх төрлийн зэвсэг, салют, пүүжин, хонгио, сум, дарь, нитроглицерин, шахаж савласан хий, агаар, бутан, метан, бусад шингэн хий болон тэсрэх, шатамтгай бодисний хэрэглээ, ашиглалт, тээвэрлэлттэй холбоотой учирсан хохирол;
27. Монгол улсын нутаг дэвсгэрээс гадна явуулсан үйл ажиллагаанаас учирсан хохирол;
28. Төлбөрийн чадваргүй болох эрсдэл;
29. Дайн, дайн бүхий байдал, зэвсэгт бослого, байлдааны зэвсэг хэрэглэх, үймээн самуун, террорист үйл ажиллагаа, бослого, ажил хаялт, төрийн захиргааны байгууллагын акт шийдвэр, улс төрийн тэмцэлд оролцсон, цөмийн дэлбэрэлт, цацраг идэвхт бодис буюу туяаны хордлого;
30. Хууль тогтоомжинд заасан бусад үндэслэлүүдээр даатгагч тус тус даатгалын нөхөн төлбөр олгох үүрэг хүлээхгүй.